



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯНХУТАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 5/26

Баянхутаг сум

**Үр дүнгийн урамшуулал
олгох тухай**

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Засгийн Газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам", Засгийн Газрын 2023 оны 422 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Соёлын төвийн дарга С.Мөнххэрлэн нь 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг хангалттай сайн үнэлгээтэй биелүүлсэн тул үндсэн цалингийн 50 (тавь) хувиар урамшуулал олгосугай.

2. Үр дүнгийн урамшууллыг 12 дугаар сарын цалинтай хамтатган тооцож олгохыг нягтлан бодогч /Х.Энхцэцэг /-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Д.БАЙГАЛМАА